



2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НИЙСЛЭЛИЙН ДОТООД
АУДИТЫН АЛБА



НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Нэгдүгээр бүлэг. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

а/ “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал-2030”

3.2.3. Төсөв, санхүүгийн салбарын аюулгүй байдал

3.2.3.1. Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, урт хугацааны өсөлт хөгжлийг дэмжих эрүүл, тогтвортой, сахилга баттай санхүүгийн салбарыг төлөвшүүлнэ.

“Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал-2030”-ын дээрх заалтууд нь “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5.3.11, “Нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2017 оны үндсэн чиглэл”-ийн 5.33 дахь заалтуудтай нийцэж байна гэж үзэж байна.

б/ Төрөөс дотоод аудитын талаар баримтлах бодлогыг одоогоор тодорхойлоогүй байна.

в/ Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр

1.1. Төсвийн нэгдмэл байдлыг ханган, төсвөөс гадуурх санхүүжилтийг зогсоож, хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгох замаар үр ашгийг нэмэгдүүлнэ.

1.2. Төсвийн сахилга батыг сайжруулж, үр ашиггүй зардлыг танах, хэмнэлтийн горимд шилжүүлэх замаар төсвийн алдагдлыг бууруулна.

“Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн дээрх “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал-2030”-ын дээрх заалтууд нь “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5.3.11, “Нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2017 оны үндсэн чиглэл”-ийн 5.33 дахь заалтуудтай нийцэж байна гэж үзэж байна.

г/ Улсын болон нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажил байхгүй болно.

д/ Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд дотоод аудитын талаар тусгасан заалт байхгүй болно.

е/ Нийслэлийн Дотоод аудитын албанд байгууллагын үндсэн чиг үүрэг болох дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын чиглэлээр хэрэгжүүлж буй үндэсний хөтөлбөр байхгүй болно.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн зорилтууд, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг өөрийн байгууллагын хэмжээнд зохион байгуулж, хэрэгжилтийг зохих хугацаанд нь тайлагнаж ажилласан.

ж/ “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага” нийслэлийн хөгжүүлэх хэтийн зорилтод дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын талаар зорилт байхгүй болно.

з/ Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр

5.3.11. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдүүлж хэвшүүлнэ.

“Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн дээрх заалт нь “Нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2017 оны үндсэн чиглэл”-ийн 5.33 дахь заалттай нийцдэг.

5.3.12. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод хяналтыг сайжруулах замаар ажлын байрны эмх цэгц, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх тогтолцоонд бүрэн шилжүүлнэ.

“Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн дээрх заалт нь “Нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2017 оны үндсэн чиглэл”-ийн 5.34 дэх заалттай нийцдэг.

к/ Нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2017 оны үндсэн чиглэл

5.33. Нийслэлийн хэмжээнд төсвийн хамнэлтийн горимыг хэрэгжүүлэн, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, санхүү, төсөв, нягилан бодох бүртгэлийн сургалтыг үе шаттай зохион байгуулах замаар төсөв санхүүгийн сахилга батыг чанд мөрдүүлж ажиллана.

Нийслэлийн Дотоод аудитын алба нь 2017 онд нийслэлийн Засаг даргын хамрах хүрээний нийт 34 байгууллагад гүйцэтгэл, нийцлийн аудит болон санхүүгийн хяналт шалгалтын ажил гүйцэтгэсэн.

Өмнөх онд төсвийн хүрээний 32 байгууллагад дотоод аудит хийсэнтэй холбогдуулж төсвийн хөрөнгийг үргүй зарцуулсан, хөрөнгө оруулалтыг үр өгөөжгүй ашигласан зэрэг илэрсэн асуудлуудыг давтан гаргахгүй байх 263 удаагийн зөвлөмж өгсний хэрэгжилтийг шалгахад 90,0 орчим хувийн биелэлттэй байгаа нь Нийслэлийн төсвийн хүрээний байгууллагууд дотоод аудит, хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгахад анхаарч ирснийг харуулж байна. Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйл, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн заалтын дагуу тус алба нь тайлант онд төсвийн орлого бүрдүүлэлтэд аудит хийж, дүгнэлт гаргахаар төлөвлөсний дагуу Нийслэлийн Татварын газар, Нийслэлийн Улсын бүртгэлийн газар, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Онцгой байдлын газар зэрэг нийслэлийн төсвийн орлого бүрдүүлдэг байгууллагад дотоод аудитыг гүйцэтгэсэн.

Нийслэлийн төсвийн хүрээний зарим байгууллагын удирдлагын болон байгууллагын үйл ажиллагааны дутагдал, доголдлын талаар иргэдээс Нийслэлийн Засаг даргад хандан гаргасан 5 удаагийн өргөдөл, гомдлыг шалган барагдуулаад байна.

Тус алба нь төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалтад дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийж үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангаж, тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх чиг үүргийнхээ хүрээнд ажиллаж байна.

Тус алба нь Нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан 3 ажлын хэсэгт ажиллан, ажлын хэсгийн удирдамжид тусгагдсан холбогдох зорилтуудын хяналт шалгалтын материалуудыг гарган өгч тайланд нэгтгүүлсэн.

Мөн Сангийн яамны удирдамжийн дагуу нийслэлийн Нийгмийн халамжийн газар, нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар, нийслэлийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын

газруудад санхүүгийн хяналт шалгалт хийж, шалгалтын материалуудыг нэгтгэн Сангийн яаманд хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтуудын хүрээнд Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа 69 байгууллага, 9 дүүргийн 484 байгууллага, нийт 553 байгууллагын шилэн дансны 2016 оны 04 дүгээр улирал, 2017 оны 1,2,3 дугаар улирлын тайланг Сангийн яаманд цахимаар хүргүүлсэн. Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын хүрээний 69 байгууллагын мэдээллийг шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд хандан 2016 оны 12 сар, 2017 оны 01-11 дүгээр саруудад хянаж зөрчлийг залруулуулан ажилласан.

Нийслэлийн Засаг даргын 2017 оны 16 дугаар удирдамжийн хүрээнд Шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилтийн үзлэг шалгалтыг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 08 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацааг хамруулан нийслэлийн ТЕЗ-ийн харьяа төсөвт 50, аж ахуйн тооцоот 19 нийт 69 байгууллагад хийж гүйцэтгэсэн аудитад тус тус дараалсан хяналт тавьж ажилласан.

Мөн аудитаар хууль болон журмыг хэрэгжүүлээгүй, хангалтгүй хэрэгжүүлж байгаа нийт 4 байгууллагад албан шаардлага хүргүүлээ.

2016-2017 онд санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчдын тавьсан актаар нийслэлийн төсөвт 38.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн.

5.34. Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудын дотоод хяналтын үйл ажиллагааг үнэлж, холбогдох арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх замаар байгууллагуудын дотоод хяналтыг тогтолцоог сайжруулна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний 91 байгууллагын эрсдэлийн үнэлгээг хийсэн. Эрсдэлийн үнэлгээгээр “Их эрсдэлтэй” 23, “Дунд эрсдэлтэй” 11, нийт 34 байгууллагад 2017 онд аудит хийхээр төлөвлөсөн.

Нийслэлийн Засаг даргын баталсан аудитын жилийн төлөвлөгөөний дагуу Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний 33 байгууллагад санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудит болон хяналт шалгалтын үйл ажиллагааг явуулахдаа төсвийн хэтрэлт, хэмнэлтийн байдлыг тухай бүр тогтоож ирлээ.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Дотоод аудитын хорооны даргын захиалгаар 2012-2016 онуудад нийслэлийн хөрөнгө оруулалтаар хийсэн ажлын гүйцэтгэлд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс болон Засаг даргын дэргэдэх агентлаг, харьяа байгууллагуудыг хамруулан гүйцэтгэлийн аудит хийж, дүнг Нийслэлийн Засаг даргад танилцуулсан. Аудитад хамрагдсан байгууллагуудад тайлан зөвлөмжийг хүргүүлж, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Тус алба нь тайлант хугацаанд гүйцэтгэсэн аудит, хяналт шалгалтаар нийт 156,980.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнээс улсын ахлах байцаагчийн 20 актаар 11 байгууллагад нийт 17,770.5 сая төгрөгийн төлбөр тогтоосноос 112.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт, 17,658.1 сая төгрөгийг тухайн байгууллагад нь барагдуулан, улсын байцаагчийн 4 албан шаардлагаар 8,049.2 сая төгрөгийн зөрчлийг арилгуулсан.

Нийт 23 байгууллагад 130 зөвлөмж өгч, илэрсэн 131,160.5 сая төгрөгийн зөрчлийг цаашид дахин давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэн ажилласан. Тайлант хугацаанд тогтоосон улсын байцаагчийн актны 99.5 хувь буюу 17,683.1 сая төгрөгийг барагдуулж ажилласан.

л/ Нийслэлийн Дотоод аудитын албанд байгууллагын үндсэн чиг үүрэг болох дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын чиглэлээр хэрэгжүүлж буй дэд хөтөлбөр байхгүй болно.

"Авлигын эсрэг нийслэлийн хөтөлбөр"-ийн зорилтууд, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг өөрийн байгууллагын хэмжээнд зохион байгуулж, хэрэгжилтийг зохих хугацаанд нь тайлагнаж ажилласан.

Хоёрдугаар бүлэг. ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

а/ Нийслэлийн Дотоод аудитын албаны үйл ажиллагаатай холбоотой 26 төрлийн дээд газрын тогтоол, шийдвэр, албан даалгавар, өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг зохих хугацаанд нь холбогдох байгууллагад тайлагнаж ажилласан.

б/ Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч С.Батболд “2017 оныг “Иргэдийн оролцоотой эрх зүйн шинэтгэлийн жил” болгон зарласантай холбогдуулан энэ хүрээнд нийслэлийн хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө баталсан. Энэхүү төлөвлөгөөтэй уялдуулан байгууллагын хэмжээнд “Иргэдийн оролцоотой эрх зүйн шинэтгэлийн жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж, НЗДТГ-ын ХЭЗХ-т тайлагнаж ажилласан.

Гуравдугаар бүлэг. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

а/ Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн үүрэг буюу нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад хийх дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын ажлыг 2017 оны аудитын төлөвлөгөөний дагуу хугацаанд нь 100 хувь гүйцэтгэсэн.

6/ ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ, ТОГТВОР СУУРЬШИЛТАЙ АЖИЛЛУУЛАХ ТАЛААР БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

Зорилт	№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Зүрилтот түвшин (Тоо хэмжээ, хувь)	Хүрсэн түвшин (Хэрэгжилтийн хувь, тоо хэмжээ)	Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр гүйцэтгэлээр (мян.төг)	Тайлбар
1. Хүний нөөцийг чадавхжуулах	1	Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан гадаад, дотоодын сургалт	Дотоод сургалтын тоо	5-аас дээш	7	3,250.0	
			Албан хаагчдын хамрагдсан байдал	80 хувиас дээш	85%		
			Гадаад сургалтад албан хаагчдын хамрагдсан байдал	20 хувиас дээш	0%		
	2	Мэргэшсэн, туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэх	3 болон түүнээс дээш жил ажилласан мэргэшсэн боловсон хүчний үзүүлэлт	70 хувиас дээш	91.3%		
	Хэсгийн дундаж:					58.8%	
2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах	3	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	Шагнал, урамшуулалд хамрагдсан албан хаагчдын тоо	Гүйцэтгэлээр	21	24,926.5	
			Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан олгох нэмэгдэл, зэрэг дэв, шатлал ахиулах	Гүйцэтгэлээр	32	39,034.0	
	4	Албан хаагчдын ажлын байрны	Ажлын байрны таатай орчны сэтгэл	Сэтгэл ханамж 80 хувиас дээш	81.5%		

	хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн байдал	ханамжийн санал асуулга				
		Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны зардлыг нэмэгдүүлэх	Гүйцэтгэлээр	27	16,549.7	
5	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг	Жилд 1-ээс доошгүй удаа	1	-	
		Албан хаагчдын хамрагдалт	100 хувь	100%		
	Хэсгийн дундаж:			100%		
Үнэлгээний дундаж хувь:				79.4%		

в/ Байгууллагын үй ажиллагааны үр дүнг үнэлэх гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт /KPI/ одоогоор тодорхойлогдоогүй байна.

г/ Байгууллагад нийт 35 өргөдөл ирснийг тухай бүр бүртгэн удирдлагад шилжүүлсэн. Нийт 30 өргөдлийг иргэний талд, 4 өргөдөлд шийдвэрлэх боломжгүй гэсэн хариу өгсөн ба 1 өргөдлийг судалж байна. Шийдвэрлэсэн бүх өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэсэн. Байгууллагын хэмжээнд өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 6 хоног 9 цаг 20 минут байгаа нь нийслэлийн зорилтот түвшин /9 хоног 23 цаг 59 минут/-д хүрсэн байна. Энэ нь нийслэлийн дундаж индексээс 0.0847 нэгжээр дээгүүр, нийслэлийн хэрэгжүүлэгч агентлагуудаас 0.146 нэгжээр дээгүүр үзүүлэлттэй байна.

д/ Байгууллагын албан ажлын хэрэгцээнд 59 нэр төрлийн 917 ширхэг 4.0 сая төгрөгийн бараа материалыг худалдаж авч, 59 нэр төрлийн 1016 ширхэг 4.7 сая төгрөгийн бараа материалыг албан хэрэгцээнд зарлагдсан. Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдлөг болгон бараа материалын тайлан, жижиг мөнгөн сангийн тайланг гарган, хагас, бүтэн жилээр эд хөрөнгийн тооллого явуулсан. Байгууллагын эд хөрөнгөд учирсан хохирол, гэмтэл үгүй, хадгалалт хамгаалалт хэвийн байна.

е/ 2017 онд нийт 14 удаагийн нийслэлийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгсөн 38 төрлийн үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр, хяналтад байгаа дээд газрын 26 тогтоол, шийдвэрийн гүйцэтгэлийн мэдээг улирал бүр гарган L monitoring програмаар хугацаанд нь тайлагнасан. Мөн нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг улирал тутам дээрх програмаар хугацаанд нь тайлагнажээ.

Дөрөвдүгээр бүлэг. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ
ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал			
1.	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байгууллагын танилцуулга, шинэчилсэн дүрэм, эрхэм зорилго, стратегийн зорилт, бүтэц зохион байгуулалтын схемийг ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчилсэн.	100%
2.	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Архив, бичиг хэргийн ажилтан болон бусад албан хаагчидтай холбоо барих хаяг, утасны дугаар, цахим хаяг, албан хаагчдын бусад мэдээллийг байгууллагын цахим хуудас, өргөдөл гомдлын smartcity.mn програмд ойлгомжтой байдлаар байршуулж, өөрчлөлт орсон тухай бүр шинэчлэн ажилласан.	100%
3.	Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдлага, санхүү, дотоод хяналтын ажилтнуудад зориулан дотоод аудитын талаарх ойлголт, гарын авлага, стандарт, заавар, загвар, дотоод аудит хийхэд шаардлагатай нийтлэг баримт бичгийн жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулсан.	100%
4.	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой	Нийслэлийн дотоод аудитын албаны үндсэн чиг үүрэг болох нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийхэд дагаж мөрдөж буй болон төрийн захиргааны байгууллагын хувьд үйл ажиллагаандаа мөрддөг хууль тогтоомж, дүрэм журмын	100%

	байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	жагсаалтыг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбартаа байрлуулсан.	
5.	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах;	Тус байгууллага нь нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг учир бодлогын баримт бичиг боловсруулах, захиргааны хэм хэмжээний акт гаргах чиг үүрэггүй болно.	-
6.	Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;	Дотоод аудитын олон улсын мэргэжлийн практикийн хүрээний дагуу дотоод аудит хийх аргачлал загвар, ажлын баримтуудыг шинэчлэн боловсруулах шатанд албаны бүх албан хаагчдад ажлын баримтууд, тэдгээрийн агуулгатай холбоотой сургалт, хэлэлцүүлгийг 3 удаа зохион байгуулсан. Дотоод аудитын шинэчлэгдсэн гарын авлага, ажлын баримтууд, шинэ аргачлалын дагуу нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газарт гүйцэтгэлийн аудитын хийсэн.	100%
7.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх;	Нийслэлийн Дотоод аудитын албаны чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэсэн тохиолдол үгүй болно.	-
8.	Тухайн байгууллага тодорхой төрлийн аж	Нийслэлийн Дотоод аудитын алба нь тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа	-

	ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	болон бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодоггүй болно.	
9.	Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх;	Нийслэлийн Дотоод аудитын албанд салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр байхгүй болно.	-
Хэсгийн дундаж хувь:			100%
Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал;			
1.	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах;	Тайлант онд нийслэлийн Дотоод аудитын албанд ажлын байрны сул орон тоо гараагүй тул цахим хуудас болон мэдээллийн самбартаа энэ талаарх мэдээлэл тавигдаагүй.	-
2.	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Нийслэлийн дотоод аудитын албаны албан хаагчдын мөрддөг “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”, “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын ёс зүйн дүрэм”, “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтны ёс зүйн дүрэм”, “Дотоод аудиторын ёс зүйн дүрэм”-үүдийг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбартаа байрлуулсан.	100%
3.	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг	Албан хаагчдын ажлын идэвх санаачлагыг дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор Хүний	100%

	цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	нөөцийн хөгжлийн хөтөлбөр, Албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх дунд хугацааны “Хүний нөөцийн сургалтын хөтөлбөр”, 2017 оны сургалтын төлөвлөгөө, тэдгээрийн хэрэгжилтийн тайланг байгууллагын цахим хуудсанд байрлуулсан.	
4.	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	Албан хаагчдын ажлын идэвх санаачлагыг дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах сонирхлыг нэмэгдүүлэх, тэдний нийгмийн баталгааг хангах, мэргэжлийн ур чадварыг сайжруулах, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар хүний нөөцийн тайланг байгууллагын цахим хуудсанд байрлуулсан.	100%
5.	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	ТАЗ-ийн 2012 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар баталсан “Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам”, Менежерийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам”, Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам” болон дээрх журмуудын хавсралтаар баталсан төсвийн шууд захирагч, менежер, төрийн жинхэнэ албан хаагчийн үр дүнгийн гэрээ байгуулах, үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэх загварыг тус тус байгууллагын цахим хуудсанд байрлуулсан.	100%
Хэсгийн дундаж хувь:			100%
Хэрэгжилтийн дундаж хувь:			100%

Тавдугаар бүлэг. БУСАД МЭДЭЭЛЭЛ

БҮТЭЦ, ОРОН ТОО, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХҮНИЙ НӨӨЦ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

Нийслэлийн Дотоод аудитын алба нь Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэх, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудын эрсдэлийн удирдлага, засаглал, дотоод хяналт, санхүүгийн үйл явцыг үнэлж, дүгнэлт, зөвлөмж өгөх, үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх үндсэн үүрэг бүхий Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг юм.

Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудын эрсдэлийн удирдлага, засаглал, дотоод хяналтын үйл явцыг хараат бус, бие даасан

байдлаар үнэлэн дүгнэлт, зөвлөмж өгч, үйл ажиллагааг сайжруулахад манай эрхэм зорилго оршино.

Эрхэм зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг тодорхойлон байгууллагын жилийн болон дунд хугацааны төлөвлөгөөнд тусган нийслэлийн Дотоод аудитын хорооны даргаар батлуулан ажилласан. Үүнд:

1. Байгууллагын стратегийг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж болох дотоод, гадаад эрсдэлүүдийг тодорхойлох, үнэлэх, бууруулах үйл явцыг тасралтгүйгээр хэрэгжүүлэх;
2. ТЕЗ болон дотоод аудитын хороог аудитын үнэн бодитой мэдээллээр хангах замаар дотоод аудитын мөн чанар, үр нөлөө, үр ашигтай байдлыг таниулах;
3. Аудитын төрлүүд болон байгууллагуудын онцлогт тохирсон аудит хийх аргачлалыг Дотоод аудитын мэргэжлийн практикын олон улсын стандартууд, Санхүүгийн хяналт шалгалтын стандартын хүрээнд боловсруулан, мөрдөж ажиллах;
4. Аудитыг үр өгөөжтэй, чанартай гүйцэтгэхэд шаардлагатай нөөцүүдийг оновчтой удирдаж, байгууллагын хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг хангах.

Байгууллагын дүрмээр хүлээсэн үүрэг, зорилго, зорилтыг хангахын тулд дараах ажлуудыг 2017 онд хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Нийслэлийн Дотоод аудитын албаны 2017-2020 оны аудитын дунд хугацааны төлөвлөгөөг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан шинээр боловсруулан баталсан.

Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч Дотоод аудитын албаны даргатай 2017 оны үр дүнгийн гэрээг 2017.01.25-нд байгуулснаар байгууллагын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Мөн өдөр 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр нийслэлийн Дотоод аудитын албаны дарга, нэгжийн менежерүүдтэй, нэгжийн менежерүүд албан хаагчидтай 2017 оны үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээг байгуулж, хэлтсийн болон албан хаагчдын тухайн жилийн ажлын төлөвлөгөөг баталсан.

Байгууллагын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулан боловсруулсан бөгөөд төлөвлөлтийг хийхдээ байгууллага, хэлтсийн болон албан хаагчдын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, байгууллагын үйл ажиллагааны бусад дэд төлөвлөгөөнүүдийг хооронд нь оновчтой уялдуулах талаар анхаарч ажиллалаа. Тухайлбал, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уядуулан 2017 оны аудитын төлөвлөгөө, ёс зүйн хорооны, өмч хамгаалах байнгын зөвлөлийн, баримт бичиг нягтлан шалгах комиссын, сургалтын, биеийн тамир, спортын хамтлагийн, агаарын бохирдлыг бууруулах ажлын, 2016 оны үйл ажиллагааг үнэлсэн ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийн дагуу гүйцэтгэл сайжруулах ажлын төлөвлөгөө, нийслэлийн Аудитын газрын зөвлөмжийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөө, “Иргэдийн оролцоотой эрх зүйн шинэтгэлийн жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнүүдийг боловсруулан батлуулж ажилласан.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын 2016 оны үйл ажиллагааны үр дүнг шалган зааварлах ажлын хэсэгт ажлаа амжилттай тайлагнасан бөгөөд тус ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнаж ажилласан.

2. Байгууллагын архив, албан хэргийг заавар, журмын дагуу хөтлөн явуулах чиглэлээр:

Архивын хууль тогтоомжийн дагуу нэгдүгээр улиралд байгууллагын архивт баримт хүлээн авах хуваарийг гарган батлуулж, 2016 оны цаасан суурьтай түр хадгалах 130, байнга хадгалах 38, 70 жил хадгалах 4, нийт 172 архивын хадгаламжийн нэгж, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад зааснаар нийт 5 цахим баримтыг хүлээн авч нөхөн бүрдүүлэлтийг хийсэн. Үүнээс аудитын ажилтай холбоотой архивын нэгж 105 байсан бөгөөд Захиргаа, хуулийн хэлтсийн 60, Санхүүгийн аудитын хэлтсийн 31, Гүйцэтгэлийн аудитын хэлтсийн 78, Чанарын хяналтын хэлтсийн 3 нэгж, 7615.22 МВ багтаамжтай цахим баримтыг архивт хүлээн авсан. Архив, бичиг хэргийн ажилтны орон тоо бий болсонтой холбогдуулан өмнө энэ ажлыг хариуцаж байсан албан хаагчаас байгууллагын архивыг хүлээлцүүлж, 2014 оны 137, 2015 оны 178 архивын хадгаламжийн нэгж, 5 цахим баримтад нягтлан шалгалт хийж, баримтын бүрдлүүдийг гүйцээн, хадгаламжийн нэгжийн дугаар, бүртгэлийн зөрүүтэй байдлыг засварлан, нөхөн бүрдүүлэлтийг хийлээ.

Байгууллагын архивын данс, бүртгэлийг шинээр үйлдсэн бөгөөд байгууллагын түүхчилсэн лавлах /баримтын тодорхойлолт, хөмрөгийн баримтын түүх/-ыг нэмж баяжуулан бичсэн. Нийслэлийн Архивын газраас 2016 оны нөхөн бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар 86 хувийн үнэлгээтэйгээр дүгнүүлсэн. Уг шалгалтаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжилтийг тайлагнан хүргүүлсэн. Нийслэлийн засаг даргын А/688 дугаар захирамжийн дагуу байгууллагын Архивын нэгдсэн тооллого явуулж, дүн мэдээг ББНШК-ын хурлаар хэлэлцүүлж, тооллого явуулсан тухай илтгэх хуудсыг хугацаанд нь Нийслэлийн Архивын газар руу хүргүүлсэн. Байгууллагын бүтэц өөрчлөгдсөнтэй холбоотойгоор хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг байгууллагын чиг үүрэг, стратеги төлөвлөгөөтэй уялдуулан шинэчлэн боловсруулж, НББНШАЗК-оор батлуулахаар төслийг Нийслэлийн Архивын газарт хүргүүлсэн.

Байгууллагын албан хэрэг хөтлөлтийг холбогдох стандарт, зааврын дагуу зохион байгуулж, Нийслэлийн Архивын газраас шинээр гаргаж хэрэглээнд нэвтрүүлж буй албан хэрэг хөтлөлтийн Edoc програмын шинэчилсэн хувилбарыг албан хаагчдын компьютерт суулган, холбогдох мэдээллийн баазыг програмд оруулан албан хэрэгцээнд ашиглаж байна. 2017 оны эхний 12 сарын 20-ны байдлаар байгууллагын хэмжээнд нийт 258 албан бичиг ирсэнээс 90 хариутай бичгийн шийдвэрлэлтийн хугацаанд хяналт ажилласан. Гадагш явуулсан 187 албан бичгийн бүрдэл, стандартыг ханган боловсруулж, тухай бүр програмд бүртгэн холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Баримт бичгийн эргэлтийн тайланг 14 хоног тутамд гарган хянасан. “Edoc” програмаар хэвлэмэл хуудсыг захиалж хэвшсэн бөгөөд 3 удаа нийт 300 ширхэг хэвлэмэл хуудас захиалж, хэвлэмэл хуудасны зарцуулалтад хяналт тавин, бүртгэл хөтөлж, эхний хагас жилийн хэвлэмэл хуудасны зарцуулалтын мэдээг гаргасан. Бүх албан хаагчдыг “Edoc” програмын сургалтад хамруулан, програмд нэвтрэх нэр, нууц код олгон, албан хаагчдыг програм ашиглахтай холбогдсон мэдээлэл, арга зүйгээр тухай бүр хангаж ажилласан.

3. Байгууллагын үйл ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгох, эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр:

Монгол улсын Сангийн яам, НЗДТГ-ын ХЭЗХ-т “Дотоод аудитын тухай хууль”-ийн төсөлд, Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн сургалтын үеэр нягтлан бодох бүртгэл, түүний холбогдох стандарт, Сангийн сайдын тушаалуудад өөрчлөлт оруулах

тухай, мөн Монгол Улсын болон Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд оруулах саналаа боловсруулж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

Байгууллагын өдөр тутмын болон аудитын үйл ажиллагаатай холбоотой хууль, эрх зүйн актуудыг албан хаагчдад танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.

2017 онд байгууллагын даргын 63 тушаалыг албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын холбогдох заалтуудад нийцүүлэн гаргасан бөгөөд дээрх тушаал шийдвэр хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг хянан зөвлөгөө өгч, байгууллагын даргын өмнө гаргасан 11 тушаалд кодификаци хийн, бүртгэл хөтөлсөн.

Байгууллагын бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнөөр зарим нэгжийн нэр, чиг үүрэгт өөрчлөлт орсон, мөн зарим албан тушаал хасагдаж, нэмэгдсэн тул захиргааны хэлтсийн дарга, ахлах нягтлан бодогчийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн, архив, бичиг хэргийн ажилтны ажлын байрны тодорхойлолтыг шинээр боловсруулан батлуулж, мөрдөн ажилласан.

Байгууллагын дүрэм шинэчлэн батлагдсантай холбогдуулан байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулж батлуулан мөрдөн ажилласан. Мөн даргын зөвлөл, байгууллагын дэргэдэх баримт бичиг нягтлан шалгах комисс, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийг байгууллагын даргын тушаалаар шинэчлэн байгуулж, холбогдох дүрэм, журмыг шинээр болон шинэчлэн боловсруулж батлуулан, ажлын төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг ханган тайлагнаж ажилласан. Нийслэлийн Өмчийн харилцааны газраас “Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-г дүгнэж, тус байгууллагад 100 хувь буюу бүрэн хангалттай үнэлгээ өгсөн.

Байгууллагын дэргэдэх ёс зүйн хороог шинэчлэн байгуулах нууц санал хураалт явуулснаар ёс зүйн хорооны даргаар орлогч дарга Д.Энхбат, гишүүдээр Гүйцэтгэл, нийцлийн аудитын хэлтсийн дарга Ж.Жамбалдорж, ахлах аудитор Д.Нансалмаа нарыг байгууллагын даргын 2017 оны 02 дугаар сарын 09-ний А/04 тушаалаар томилсон. 2017 оны байдлаар албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаар гомдол санал ирээгүй. Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон “Ёс зүйн дүрэм”-ийг шинээр боловсруулан мөрдүүлэхээр байгууллагын дэргэдэх Ёс зүйн хороо холбогдох бусад ёс зүйн дүрэм (Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын ёс зүйн дүрэм, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтны ёс зүйн дүрэм, дотоод аудитын ёс зүйн дүрэм, Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийг ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрэм)-үүдийг судалж байна.

Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд шаардлагатай ном товхимолыг санг улирал тутмын “Татвар ба Бизнес” сэтгүүлээр баяжуулсан бөгөөд хуулийн эмхтгэл, нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон хэм хэмжээний эмхтгэл, нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газраас гаргасан цуврал 12 боть номоор номын санг баяжуулсанаар одоо нийт 97 ном, эмхэтгэл, гарын авлагатай болж аудитор, шинжээчдийн ажлын хэрэгцээнд ашиглуулсан.

АТГ-ын даргын тушаалаар батлагдсан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалтын дагуу 12 албан хаагчийн 2016 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг 2 дугаар сарын 15-ны дотор буюу хуулийн хугацаанд нь хүлээн авч, тайлан мэдээг гаргаж өгсөн. 2017 онд 3 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ-аар хянуулж томилсон. Оны эхний 11 сарын байдлаар аудитор, шинжээчдээс аудитын ажил

эхлэх бүрт ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай 96 мэдэгдэл хүлээн авч, АТГ-ын програмд бүртгэсэн.

Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017.04.18-ны өдрийн хуралдаанаар Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын даргын буруутай шийдвэрийн улмаас иргэнд учирсан хохирлыг тухайн байгууллагаар төлүүлэхээр шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг биелүүлж, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д заасны дагуу буруутай этгээдээр буцаан төлүүлэх асуудалд хяналт тавьж ажилласнаар хохирлыг бүрэн барагдуулсан.

Интернэтийн үйлчилгээг Нийслэлийн мэдээлэл технологийн газар, Комтел ХХК-аас 2mb-ын урсгалыг авч байна. Байгууллагын 22 компьютер, бусад техник хэрэгсэл дотоод, гадаад сүлжээнд бүрэн хэмжээгээр холбогдон ажиллаж байгаа бөгөөд эдгээр 22 суурин компьютер, 2 зөөврийн компьютерт албан ёсны эрхтэй хортой кодны эсрэг Kaspersky програм хангамж суулгаж, дотоод сүлжээнд холбогдож байгаа компьютерүүдийг өөр хоорондоо нэвтрэх нэр, нууц үгийг идэвхжүүлж мэдээллийн урсгалыг хязгаарлан аюулгүй байдлыг ханган ажилласан.

4. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг хууль, журамд нийцүүлэн улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу хөтлөн явуулах чиглэлээр:

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын салбарын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт дагуу бүртгэн, сар бүр төсвийн гүйцэтгэл, тухай бүр жижиг мөнгөн сангийн болон материалын тайлан, улирал бүр санхүүгийн тайланг гаргаж, нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хуулийн хугацаанд хүргүүлэн баталгаажуулж ажилласан. Нийслэлийн Аудитын газарт байгууллагын 2016 оны жилийн эцсийн, 2017 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг баталгаажуулж зөрчилгүй санал дүгнэлт авсан.

Хөдөлмөрийн тухай хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу байгууллагын нийгмийн даатгалын тайланг сар бүр гаргаж, онлайн програмд шивж цаасаар хүргүүлэн баталгаажуулсан. 2017 оны эхний 11 сарын байдлаар нийт 24 албан хаагчийн 39.5 сая төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэл төлсөн. Хөдөлмөрийн тухай хууль болон ХХОАТ тухай хуулийн дагуу байгууллагын ХХОАТтайланг улирал бүр гаргаж, цахим програмд шивэн цаасаар баталгаажуулсан. Нийт 24 албан хаагчийн ХХОАТтайланг гаргаж, тайлант хугацаанд 16.0 төгрөгийг ХХОАТ-т шилжүүлсэн.

2017 онд нийслэлийн Төрийн сантай санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчдын тавьсан актын тооцоо хийж, нийслэлийн төсөвт 38.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн.

Байгууллагын үндсэн хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хянаж, хөрөнгийн хөдөлгөөнийг тухай бүр бүртгэж ажилласан. 2017 онд нийт 40 нэр төрлийн 120.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг тоолсон.

Нийслэлийн Өмчийн харилцааны газраас Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээг дүгнэж, тус байгууллагад 100 хувь буюу бүрэн хангалттай үнэлгээ өгсөн.

5. Байгууллагын хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх чиглэлээр:

Албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх дунд хугацааны “Хүний нөөцийн сургалтын хөтөлбөр”, 2017 оны сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр 2017 оны төсөвт 5.5 сая төгрөгийг батлуулсан.

Үүний дагуу нийт албан хаагчдад эерэг хандлагын сургалт, С.Цолмон МНБ аудиторын сургалт, Ц.Дуламдорж МНБ хугацаагүй эрх сургалт, Я.Сарансүх хуульчийн үргэлжилсэн сургалт, архив, бичиг хэргийн ажилтан Б.Мягмардулам архив, бичиг хэргийн мэргэжлийн сургалтад тус тус хамруулж, нийт 3.3 төгрөг албан хаагчдын сургалтад зарцуулсан.

Дотоод аудитын эрчимжүүлсэн сургалтад 3 албан хаагч, Дотоод аудитын сургалт, НОБГ-аас зохион байгуулсан "Газар хөдлөлтийн гамшгийн аюулын дохиогоор ажиллах сургалт, "Бүтээлч сэтгэлгээ, эерэг хандлага", "Сэтгэцийн эрүүл мэнд, стресс менежмент", "Гэр бүл, хүүхэд хамгаалал, хүүхэд хүмүүжлийн эерэг аргууд", АТГ-т хүсэлт гаргаснаар Авлигын эсрэг хууль тогтоомж, төрийн албан хаагчдын ёс зүй, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, засаглал сургалтуудад бүх албан хаагч, ММНБИ-ийн мэргэшсэн нягтлан бодогчийн эрх сунгах сургалтад 2, Монголын Хуульчдын холбооны хуульчийн үргэлжилсэн сургалтад 1, НЗДТГ-аас зохион байгуулсан Мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах ЭБАТ-ны сургалт, Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, "Виз болон гадаад паспорт олгох эзэмших, хадгалах тухай журам", "Нутгийн захиргааны байгууллагуудын орлогч дарга нарын чадавхийг бэхжүүлэх нь", байгууллагын удирдах албан тушаалтнуудад зориулан "Ёс зүй-Сахилга хариуцлага" сургалтад байгууллагын дарга Б.Жавзан, НЗХГ-аас зохион байгуулсан "Нийслэлийн залуучуудын хөгжлийн хөтөлбөр БББ боловсруулах хэлэлцүүлэг" НГБХГ-ын Гэр бүл, хүүхэд хамгааллын сургалт, НАГ-ын "Нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам" онлайн сургалт, ТЕГ-ын "Татварын эрх зүйн шинэтгэл", Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс зохион байгуулсан "Санхүүгийн тайлан гаргахад анхаарах асуудал", Удирдлагын академийн "ТБ-ийн гүйцэтгэлийн удирдлага, яам агентлагийн түвшин дэх бодлогын үнэлгээ: Солонгосын туршлага" сургалтууд, "Иргэдийн оролцоотой эрх зүйн шинэтгэлийн жил" нийслэлийн хуульчдын зөвлөгөөнд тус тус 1 албан хаагч, НЗДТГ, ХШҮХ-ийн "Захиргааны байгууллагын ХШҮ-ний чадавхийг бэхжүүлэх нь", "Захиргааны байгууллагын бодлогын баримт бичгийн биелэлт гаргахад анхаарах асуудлууд" сургалтад, НЗДТГ-ын ХЭЗХ, ХЗДХЯамны хамтарсан Захиргааны ерөнхий хуулийн ахисан түвшний сургалт, Монголын үндэсний дотоод аудиторуудын холбооноос зохион байгуулсан "Монголын дотоод аудиторуудын форум-2017"-д тус бүр 2 албан хаагч, давхардсан тоогоор нийт 190 гаруй албан хаагчийг төрөл бүрийн сургалтад хамруулсан.

Албан хаагчдын ажлын идэвх санаачлагыг дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу шинэ байранд орсон Гүйцэтгэл, нийцлийн аудитын хэлтсийн аудитор Б.Мягмарзаяа, хүүхэд төрүүлсэн Захиргааны хэлтсийн шинжээч Б.Солонгожаргал нарт дэмжлэг, гэмтлийн улмаас удаан хугацаагаар эмчлүүлэх шаардлагатай болсон Эрсдэлийн удирдлагын хэлтсийг ахлах шинжээч Ц.Болдбаатар, нөхөр нь яаралтай хагалгаанд орж, удаан хугацаагаар эмчлүүлэх болсон Гүйцэтгэл, нийулийн аудитын хэлтсийн ахлах аудитор Н.Наранчимэг нарт тэтгэмжтэй чөлөө, тусламж, САХ-ийн шинжээч Б.Отгонцэрэнд өвлийн бэлтгэлд нь зориулж буцалтгүй тусламж, үйлчилгээний ажилтны өдрийг тохиолдуулан үйлчлэгч Я.Жавзандулам, Н.Мэндээ нарт мөнгөн шагнал олгосон бөгөөд үүнд нийт 3.6 сая төгрөгийн нэг удаагийн тэтгэмж, тусламж олгосон. Хүүхдийн баярыг тохиолдуулан албан хаагчдын хүүхдүүдэд 1.1 сая төгрөгийн бэлэг өгсөн. Бүх албан хаагчдыг эрүүл мэндийн бүрэн үзлэг, шинжилгээнд хамруулсан. "Сүү" ХК-тай хамтран "Сүүгээр эрүүлжье" сарын аянд 16 албан хаагчийг хамруулав. Энэ аяны хүрээнд албан хаагчдын кальцийн хэмжээг тодорхойлж, өдөр бүр тогтмол 1 аяга сүү, тараг, аарц хэрэглэж байгаа бөгөөд үр дүнд нь кальцийн хэмжээ өсөж, албан хаагчийн эрүүл мэндийн үзүүлэлт сайжрах юм.

Төрийн захиргааны албан хаагчдад олгох зэрэг дэвийг шинээр 1 албан хаагч авч, 6 албан хаагчийн албан тушаалын зэрэг дэв, 3 албан хаагчийн цалингийн шатлал, 1 албан хаагчийн албан тушаалын зэрэглэлийг ахиулж, 1 албан хаагч тангараг өргөж төрийн жинхэнэ албан хаагч болсон.

Албан хаагчдын ажлын гүйцэтгэлтэй нь уялдуулж оны эхний хагас жилийн байдлаар 17 албан хаагчийн үр дүнгийн гэрээ, 1 албан хаагчийн хөдөлмөрийн гэрээг дүгнэж, 15 албан хаагчид нийт 4.1 сая төгрөгийн урамшуулал өгсөн бол оны эцсийн байдлаар 19 албан хаагчийн үр дүнгийн гэрээ, 2 албан хаагчийн хөдөлмөрийн гэрээг дүгнэж, 12.0 сая төгрөгийн урамшуулал олголоо. Үйлчилгээний ажилтны өдрийг тохиолдуулан үйлчлэгч Я.Жавзандулам, Н.Мэндээ нарт мөнгөн шагнал олгосон. Мөн тогтвор суурьшилтай, идэвх зүтгэлтэй ажилласныг үнэлэн ахлах нягтлан бодогч Б.Сэргэлэнг НИТХ-ын “Хүндэт үнэмлэх”, аудитор О.Баярмагнайг нийслэлийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр шагнаж, аудитор Б.Мягмарзаяа, ахлах шинжээч Ц.Болдбаатар, ахлах нягтлан бодогч Б.Сэргэлэн, Гүйцэтгэл, нийцлийн аудитын хэлтсийн дарга Ж.Жамбалдоржийг Сангийн яамны “Жуух бичиг”, мөн Гүйцэтгэл, нийцлийн аудитын хэлтсийн дарга Ж.Жамбалдоржийг “Хууль зүйн албаны тэргүүний ажилтан” тэмдэг, төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-оор шагнуулахаар тодорхойлж, материалыг зохих байгууллагад хүргүүлээд байна. Мөн албан хаагчдын үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээний жилийн эцсийн биелэлт, үнэлгээг харгалзан аудитор Б.Уранбилэг, архив, бичиг хэргийн ажилтан Б.Мягмардулам нарыг “Оны шилдэг ажилтан”-аар шалгаруулж, тус бүр 200,000 төгрөг, ахлах аудитор С.Цолмон, аудитор Б.Мягмарзаяа нарыг “Оны шилдэгийн шилдэг ажилтан”-аар шалгаруулан 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн шагналаар шагнахаар тодруулаад байна.

Мөн байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд анхаарч, албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдарыг чийрэгжүүлэх, хамт олонч уур амьсгалыг бүрдүүлэх, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх биеийн тамир, спортын тэмцээн, арга хэмжээнүүдийг зохион байгуулах төлөвлөгөө гарган ажиллаж, 7 хоног бүр спорт зааланд тоглож, байгууллагынхаа ойд зориулан боулингийн тэмцээн, “Мөнгөн Улаанбаатар” сэдэвт цасны баяр, биеийн тамир, спортын өвлийн арга хэмжээ, “Улаанбаатар марафон” олон улсын гүйлт, Сангийн яамны Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар, нийслэл, дүүргийн дотоод аудитын албадын дундах “Дотоод аудит-2017” зэрэг спортын уламжлалт тэмцээнүүдэд баг, хамт олноо зохион байгуулан амжилттай оролцдог уламжлалтай болсон бөгөөд, Сангийн яамны Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар, Багануур дүүргийн Дотоод аудитын албатай хамтран амжилттай зохион байгуулсан “Дотоод аудит-2017” тэмцээнд сагсан бөмбөг, гар бөмбөг, дартс гэсэн 3 төрлөөр өрсөлдөж, багийн нийлбэр дүнгээр нэгдүгээр байр эзэлж, тэмцээний шилжин явах цомын эзэн болсон.

Мөн хаврын бүх нийтийн их цэвэрлэгээнд идэвхтэй оролцож, бүх нийтээрээ мод тарих ажил, хүүхдийн сувилалын хүүхдүүдэд зориулсан "Бяцхан зүрх бүхний төлөө" аянд тус бүр 100.0 мянган төгрөгийн хандив цуглуулах ажлыг зохион байгуулсан.

6. Мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр:

Үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор байгууллагын цахим хуудсанд байгууллагын танилцуулга, шинэчилсэн дүрэм, эрхэм зорилго, стратегийн зорилт, бүтэц зохион байгуулалт, дагаж мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм журам, холбоо барих хаяг, утасны дугаар, цахим хаяг, албан хаагчдын мэдээлэл, Нийслэлийн Дотоод аудитын албаны 2016 оны үйл ажиллагааны 12 төрлийн тайлан, байгууллагын дунд хугацааны төлөвлөгөө, 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, сургалтын төлөвлөгөө, агаар, орчны бохирдлыг бууруулах ажлын төлөвлөгөө, цаг үеийн мэдээ мэдээллүүд, дотоод аудитын талаарх

ойлголт, гарын авлага, стандарт, заавар, загвар зэрэг мэдээллийг нийтэлсэн. Мөн шилэн дансны тухай хуулийн дагуу аудит, хяналт шалгалтын багт ажилласан албан хаагчдын 96 “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг www.shilendans.gov.mn цахим хуудсанд хуулийн хугацаанд оруулсан.

Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу байгууллагын www.internalaudit.ub.gov.mn цахим хуудсанд санхүүгийн тайлан нийт 3 удаа, төсвийн гүйцэтгэлийн мэдээ 9, аудитын дүгнэлт 1, аудитын мөрөөр хэрэгжүүлсэн авч арга хэмжээ 1, тухайн байгууллагын жилийн төсөв 1, холбогдох материалыг нийтэлсэн. Мөн Шилэн дансны тухай хуулийн дагуу төсөв, санхүүгийн холбогдох 96 мэдээллийг www.shilendans.gov.mn цахим хуудсанд хуулийн хугацаанд оруулсан.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу байгууллагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ болон жилийн төсөв, хөрөнгөтэй холбоотой тушаал шийдвэр, санхүүгийн тайлан, таван сая төгрөгөөс дээш гүйлгээний мэдээлэл, бусад холбогдох мэдээллийг хуулийн хугацаанд нь цахим хуудсанд байршуулсан. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр 7.8 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан тухай мэдээллийг байгууллагын болон шилэн дансны цахим хуудсанд байршуулсан.

2017 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АУДИТЫН ТАЛААР:

Нийслэлийн Дотоод аудитын алба нь 2017 онд нийслэлийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний нийт 34 байгууллагад гүйцэтгэл, нийцлийн аудит болон санхүүгийн хяналт шалгалтын ажил гүйцэтгэсэн. Тайлант хугацаанд гүйцэтгэсэн аудит, хяналт шалгалтаар нийт 156,980.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнээс улсын ахлах байцаагчийн 20 актаар 11 байгууллагад нийт 17,770.5 сая төгрөгийн төлбөр тогтоосноос 112.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт, 17,658.1 сая төгрөгийг тухайн байгууллагад нь барагдуулан, улсын байцаагчийн 4 албан шаардлагаар 8,049.2 сая төгрөгийн зөрчилийг арилгуулсан.

Нийт 23 байгууллагад 130 зөвлөмж өгч, илэрсэн 131,160.5 сая төгрөгийн зөрчлийг цаашид дахин давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэн ажилласан. Тайлант хугацаанд тогтоосон улсын байцаагчийн актны 99.5 хувь буюу 17,683.1 сая төгрөгийг барагдуулж ажилласан.

1. ТӨЛӨВЛӨГӨӨТ ГҮЙЦЭТГЭЛ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЛААР:

Тайлант хугацаанд гүйцэтгэл, нийцлийн аудитын багт хэлтсийн дарга Ж.Жамбалдорж, ахлах аудитор Н.Наранчимэг, ахлах аудитор Д.Нансалмаа /2017 оны 4 дүгээр сарын 17 хүртэл/, аудитор Ц.Дуламдорж, Б.Мягмарзаяа, О.Баярмагнай, шинжээч Т.Ариунцэцэг нарын бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж чиг үүргийн дагуу аудитын ажлуудыг гүйцэтгэсэн.

Гүйцэтгэл, нийцлийн аудитаар байгууллагын дунд хугацааны төлөвлөгөө, аудитын жилийн төлөвлөгөөнд үндэслэн байгууллагуудын үйл ажиллагааны үр ашигтай ба үр дүнтэй, нөөцийн хэмнэлттэй байдалд аудитыг хийж гүйцэтгэлээ.

Тус хэлтэс гүйцэтгэл, нийцлийн аудитын зорилтуудын зарим агуулгыг шинэчлэн өөрчилж дараах зорилтуудын хүрээнд аудитыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Байгууллагын засаглалын үйл явцыг үнэлэн, нөөцийг үр дүнтэй зохион байгуулсан эсэхэд зөвлөмж өгөх;

2. Байгууллагын стратеги, бизнес, үйл ажиллагааны төлөвлөгөө болон үр дүнгийн гэрээ, контрактын хэрэгжилтэд холбогдох хууль, эрх зүйн актуудад үндэслэн үнэлэлт, дүгнэлт өгөх;

3. Дотоод хяналтын тогтолцоо, түүний үйл ажиллагаанд зөвлөмж өгөх;
4. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үр өгөөж, үр ашигтай байдал, худалдан авах ажиллагаа, холбогдох гэрээ хэлцлийн хэрэгжилтэд үнэлэлт, зөвлөмж өгөх;
5. Байгууллагын орлогын төлөвлөлт, төвлөрүүлэлт, хөрөнгийн зарцуулалт, түүний үр ашигтай байдал, өмчийн бүртгэл, хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдалд үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж өгөхөд чиглэсэн.

Захиалгат болон сэдвийн аудитын онцлогт тохируулан аудитын зорилтыг дээрхээс өөрөөр тодорхойлж, удирдамжийг тухай бүр боловсруулан батлуулж ажиллалаа. Мөн төсвийн байгууллагуудад хийх аудитын удирдамжид салбарын онцлогийг аудитын нэг дэд зорилт болгон оруулсан.

Гүйцэтгэл, нийцлийн, хамтарсан аудитыг 8 байгууллагад, 1 удаагийн захиалгат аудитыг 22 байгууллагыг хамруулан, санхүүгийн хяналт шалгалтыг 3 байгууллагад, нийт 33 удаа аудитын удирдамж боловсруулан батлуулж, аудитыг гүйцэтгэж тайлагнасан. Мөн НЗДТГ-аас байгуулсан ажлын хэсэгт ажиллаж холбогдох байгууллагуудад ажлын тайланг хүргүүлэн ажилласан.

Аудитын багийн бүрэлдэхүүн, аудитын удирдамжийг (аудитын зорилго, цар хүрээ, хугацаа зэрэг) аудит хийх байгууллагын удирдлагуудад хэлтсийн дарга байгууллага дээр нь очиж танилцуулдаг, аудитаар илэрсэн асуудлыг байгууллагын холбогдох албан тушаалтнуудад урьдчилан танилцуулж зөвшөөрүүлсэний дараа аудитын тайланг байгууллагад нь хүлээлгэн өгдөг болсон, уулзалт хийсэн тухай бүр тэмдэглэл хөтлөн албажуулж ирсэн, аудитын ажлын баримтуудын хөтлөлт сайжирсан, хийсэн аудитын дэд зорилт тус бүрт үнэлгээ өгөх төсөл боловсруулж батлуулан мөрдсөн, аудит хийх байгууллагуудад биет тест, судалгааг хийж байгаа зэрэг ажлын ололт, арга барилуудыг хэрэгжүүлж ажилласан.

Тухайн жилийн баталсан аудитын төлөвлөгөөний дагуу дараах байгууллагуудын 2016, 2017 оны үйл ажиллагаанд гүйцэтгэл, нийцлийн аудитыг хийсэн. Үүнд:

1. Бэлчээрийн менежмент төслийн нэгж
2. Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газар
3. Илч орд ОНӨААТҮГ
4. Нийслэлийн Гэр хорооллын дэд бүтцийн газар
5. Нийслэлийн Аялал, жуулчлалын газар
6. Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар
7. Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын торгуулийн орлого бүрдүүлэлт
8. Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2016, 2017 оны үйл ажиллагаа
9. Нийслэлийн Цагдаагийн газрын торгуулийн орлого бүрдүүлэлт
10. Нийслэлийн Онцгой байдлын газрын торгуулийн орлого бүрдүүлэлт
11. Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ
12. Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газар
13. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын торгуулийн орлого бүрдүүлэлт

Аудит, хяналт шалгалтыг хийж гүйцэтгэх явцад аудитад хамрагдсан байгууллагуудын хөрөнгийг бүртгэлд бүртгэх, хөрөнгийн ашиглалтыг газар дээр нь шалгах, мөнгөн касс болон зарим хөрөнгийн үлдэгдэлд хэсэгчилсэн тооллого хийх зэрэг тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд анхааран ажилласан.

Нийслэлийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, нийслэлийн Өмчийн харилцааны газар, нийслэлийн Газрын албанд шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудлуудыг албан бичиг хүргүүлсэн байна.

Батлагдсан удирдамжаар хийсэн аудит болон хяналт шалгалтын явцад доорх нийтлэг дутагдлууд илэрсэнд зөвлөмж өгөн хэрэгжилтийг хангуулж байна. Үүнд:

Нийслэлийн хэмжээнд архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэг 2015 онд явагдсан учир энэ онд хийсэн аудитаар байгууллагуудын дотоод ажил сайжирсан, тус албаны санхүүгийн болон гүйцэтгэл, нийцлийн аудитаар өгсөн зөвлөмжүүд үндсэндээ хэрэгжиж байгаа боловч өмнө ямар нэг аудит хийгдэж байгаагүй байгууллагуудаас дараах нийтлэг асуудлууд илэрч байна.

-Байгууллагын даргын зөвлөлийн хурал тогтмолжоогүй;

-Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд нийслэлийн ЗДТГ-т ирүүлдэг мэдээ, мэдээллийг хугацаа хоцроох болон ирүүлэхгүй байх;

-Байгууллагын стратеги болон бизнес төлөвлөгөөг батлуулж ажилладаггүй;

-Дотоод хяналтын систем сул, Өмч хамгаалах байнгын зөвлөл нэр төдий ажилладаг, хөрөнгийн тооллогын комисс хангалтгүй ажилласан, тэдгээрийн ажлыг дүгнээгүйгээс байгууллагын дотоодод дутагдлыг илрүүлэн арилгадаггүй;

-Санхүүгийн тайланд өглөг, авлагыг тухай бүр тусган барагдуулдаггүй;

-Орлогын төлөвлөгөө нь хоцрогдолтой, зардлын төлөвлөгөөг хэтрүүлэн контрактаар хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлдэггүй;

-Улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлтийг тухай бүр хийлгэдэггүй;

-Анхан шатны баримтгүй ажил, үйлчилгээг бүртгэл, тайланд тусгадаг;

-Тендерийн үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлийг дутуу хөтөлдөг, гаргасан шийдвэр тодорхойгүй зэрэг болно.

Байгууллагын даргын 2016 оны А/02 дугаар тушаалаар баталсан дотоод аудитын 1001-4004 аудитын ажлын баримтуудыг аудит хийсэн байгууллага, ажил нэг бүрээр хөтөлж баталгаажуулан аудитын материалд хавсаргаж байна.

"Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтад ашиг сонирхлын зөрчлөөс урдчилан сэргийлэх тухай журам"-ын холбогдох заалтын хүрээнд аудит хийх болон хийж байгаа байгууллагуудын удирдлага, албан хаагч нартай 22 удаа уулзалт хийсэн тэмдэглэлийг тухай бүр хөтөлж /Ажлын баримт 1002-ын А, Б/ албажуулсан.

Аудит хийж байгаа байгууллагуудын удирдлагаас авах асуулга, /Ажлын баримт 1003/ албан хаагчдаас авах дотоод хяналтын асуулга /Ажлын баримт 1004/-ыг 60 гаруй албан хаагчаас авч дүнг нэгтгэн аудитын тайланд тусгаж ажиллалаа.

Аудитын тайлангаар илэрсэн асуудал, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар байгууллагын дарга, ахлах /ерөнхий/ нягтлан бодогч нартай ярилцлага хийж, илэрсэн асуудлыг урдчилан ажлын баримт 3002-оор танилцуулан гарын үсэг зуруулсаны дараа аудитын тайланг албан бичгийн хамт /Аудитын тайланг хүргүүлэх хуудас, ажлын баримт 3005/ хүлээлгэн өгч байна.

Аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн мөрөөр эргэн хянах горимын хуудас ажлын баримт 4001-ийг хөтөлж, хяналтыг хэрэгжүүлж ирсэн.

2016 онд хийсэн аудитын тайлан, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн тавьсан актыг барагдуулан ажилласан.

Аудит хийсэн байгууллагуудаас нийт 7,448.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 19.4 сая төгрөгийн улсын байцаагчийн акт тавьж, 7,429.2 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх, залруулах чиглэлээр нийт 77 зөвлөмж өгч, зөвлөмжийн хэрэгжилтийн явцын тайлан авч хяналт тавин ажилласан.

2. ТӨЛӨВЛӨГӨӨТ САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЛААР:

Нийслэлийн Дотоод аудитын албаны Санхүүгийн аудитын баг нь 2017 онд хэлтсийн дарга Ч.Гүрбазар, ахлах аудитор Д.Нансалмаа /2017 оны 4 дүгээр сарын 17-ноос эхлэн/

С.Цолмон, Д.Үүрийнтуяа /2017 оны 03 дугаар сарын 31-ний өдөр хүртэл/ , Д.Лувсанчимэд / 2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр хүртэл/, аудитор Б.Ариунтуяа, шинжээч Б.Отгонцэрэн, И.Оюунгэрэл, Ж.Сайханбаяр / 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдрөөс/, Б.Ононбайгаль /2017 оны 9 дүгээр сарын 11-ний өдрөөс/ нарын бүрэлдэхүүнтэйгээр жилийн хугацаанд 1375 хүн/өдөр /давхардсан тоогоор/ ажилласан.

Тайлант хугацаанд албаны дунд хугацааны төлөвлөгөө, санхүүгийн хяналт шалгалтын жилийн төлөвлөгөөнд үндэслэн шалгалтанд хамрагдсан байгууллагуудын 2015 он, 2016 он, 2017 оны эхний 9 сарын санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийж үнэлэлт дүгнэлт өгч ажиллалаа.

Тус албаны 2017 оны аудитын жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор 14 байгууллагад санхүүгийн хяналт шалгалт хийснээс 3 байгууллагад Сангийн сайдын баталсан удирдамжийн дагуу санхүүгийн хяналт шалгалт хийсэн, Гүйцэтгэл, нийцлийн аудитын хэлтэстэй хамтран 6 байгууллагад аудит хийсэн. Мөн Нийслэлийн Засаг даргаас өгсөн чиглэлийн дагуу Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2013-2016 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд хяналт шалгалтыг хийсэн.

2017 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан 14 байгууллагын удирдамжийг боловсруулж, Дотоод аудитын хорооны даргаар батлууллаа. Үүнд:

1. “Авто худалдааны цогцолбор” ОНӨААТҮГ
2. “Хүнс хангамж” ОНӨААТҮГ
3. “Асгат” ОНӨААТҮГ
4. “Багачууд хүнс” ОНӨААТҮГ
5. “Өсвөр үе хүнс” ОНӨААТҮГ
6. “Нийслэлийн орон сууцны корпораци” ОНӨААТҮГ
7. “Хот тохижилтийн газар” ОНӨААТҮГ
8. “Геодези, усны барилга байгууламжийн газар” ОНӨААТҮГ
9. “Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар” ОНӨААТҮГ
10. “Нийслэлийн Үйлдвэр инновацийн газар”
11. “Улаанбаатар лифт” ОНӨААТҮГ

Сангийн сайдын баталсан удирдамжийн дагуу 3 байгууллага. Үүнд:

12. Нийслэлийн Нийгмийн халамжийн газар
13. Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар
14. Нийслэлийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын газар

Шалгалтын зорилгоо “Монгол улсын Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль тэдгээртэй холбогдон гарсан дүрэм, журам бусад холбогдох хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн акт, заавар журам, стандартын хэрэгжилтэнд хяналт тавих, Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2017 оны зорилтын хэрэгжилт, төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангаж тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.” гэж тодорхойлсон.

Тайлант хугацаанд хийсэн төлөвлөгөөт хяналт шалгалтаар 14 байгууллагад нийт 32,563.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнээс улсын ахлах байцаагчийн 9 актаар 3 байгууллагад нийт 424.9 сая төгрөгийн төлбөр тогтоосноос 7.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт, 417.6 сая төгрөгийг тухайн байгууллагад нь барагдуулан, улсын байцаагчийн 1

албан шаардлагаар 214.6 сая төгрөгийн зөрчлийг арилгуулсан. Нийт 10 байгууллагад илэрсэн 31,923.5 сая төгрөгийн зөрчлийг цаашид дахин давтан гаргахгүй байх зөвлөгөө өгч, зөвлөмж хүргүүлэн ажилласан.

3. ЗАХИАЛГАТ БОЛОН ХАМТАРСАН АУДИТЫН ТАЛААР:

Тайлант хугацаанд Гүйцэтгэл, нийцлийн аудитын хэлтэс, Санхүүгийн аудитын хэлтэс, Эрсдэлийн удирдлагын хэлтсүүд 1 захиалгат хяналт, шалгалт, 6 хамтарсан аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

1. НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн үйл ажиллагаанд тулгуурлан нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, харьяа газрууд зэрэг нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудын 2013-2016 онуудад хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын гүйцэтгэлд захиалгат аудит;
2. Нийслэлийн Тээврийн газар;
3. Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ;
4. Нийслэлийн Татварын газар;
5. Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ;
6. Нийслэлийн Авто замын хөгжлийн газар;
7. Нийслэлийн Газрын алба.

3.1 Захиалгат аудитын ажил:

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Дотоод аудитын хорооны дарга С.Батболдын баталсан 05 тоот удирдамжаар нийслэлийн Дотоод аудитын албаны орлогч даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Энхбатын ахалсан 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн зарим үйл ажиллагаанд буюу 2013-2016 онуудад нийслэлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн ажлын гүйцэтгэлд захиалгат хяналт, шалгалтыг гүйцэтгэсэн.

Аудитыг явуулахдаа Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Улсын салбарын дотоод аудитын гарын авлага, Олон улсын мэргэжлийн практикийн хүрээ, Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын арга зүйг удирдлага болгон ажилласан.

Захиалгат аудитаар нийслэлийн 33 байгууллагын 2013-2016 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг шалгаж нийт 61,362.8 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 62.1 сая төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн акт тогтоож, 1,827.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 59,473.6 сая төгрөгийн зөрчилд дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өгч ажилласан.

3.2 Хамтарсан аудитын ажил:

Нийслэлийн ТЕЗ-ийн харьяа 6 байгууллагад хамтарсан аудит, хянат шалгалтыг гүйцэтгэсэн. Үүнд:

1. Нийслэлийн Тээврийн газар;
2. Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ;
3. Нийслэлийн Татварын газар;
4. Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ;
5. Нийслэлийн Авто замын хөгжлийн газар;
6. Нийслэлийн Газрын алба.

Шалгалтаар нийт 55,605.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнээс улсын байцаагчийн 4 актаар 2 байгууллагад нийт 17,264.1 сая төгрөгийн төлбөр тогтоосноос 23.6 сая төгрөгийг

орон нутгийн төсөвт, 17,240.5 сая төгрөгийг тухайн байгууллагад нь барагдуулан, улсын байцаагчийн 1 албан шаардлагаар 6,007.5 сая төгрөгийн зөрчлийг арилгуулан ажилласан.

Нийт 4 байгууллагад илэрсэн 32,334.1 сая төгрөгийн зөрчлийг цаашид дахин давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэн ажилласан.

4. ШИЛЭН ДАНСНЫ ХЯНАЛТ, НЭГДСЭН ШАЛГАЛТ ТАЛААР:

4.1. Шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн ажлын хүрээнд дараах хяналтыг тавьж ажилласан.Үүнд:

- Нийслэлийн ТЕЗ, түүний харьяа 69 байгууллага, 9 дүүргийн 484 байгууллага, нийт 553 байгууллагын Шилэн дансны 2016 оны 4 дүгээр улирлын шилэн дансны тайланг, 2017 оны 1, 2, 3 улирлын тайланг Сангийн яаманд цахимаар хүргүүлсэн;
- Нийслэлийн ТЕЗ-ын хамрах хүрээний 69 байгууллагын мэдээллийг шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд хандан 2016 оны 12 сар, 2017 он 1-12 дугаар саруудад тогтмол хянаж, зөрчлийг залруулуулан ажилласан;
- Нийслэл дэх Төрийн аудитын газраас нийслэлийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилтэд хяналт, шалгалт хийж албан шаардлага, зөвлөмж өгснийг байгууллага бүрээр хяналт тавьж, залруулуулан хэрэгжилтийг албан бичгээр өгсөн.
- Шилэн дансны тухай хууль, журам, нэгдсэн цахим хуудастай холбоотой санал, тус хууль, журмыг хэрэгжүүлэхэд гарч байгаа бэрхшээл, тулгамдсан асуудлын талаар нийслэл дэх Төрийн аудитын газар, Сангийн хандан хамтран ажилласан.

4.2. Шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилтийн нэгдсэн үзлэг, шалгалт

Эрсдэлийн удирдлагын хэлтэс Шилэн дансны тухай хуулийн 8.2. “Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ.”, нийслэлийн Засаг даргын 2015 оны А/01 дүгээр захирамжийн 2. “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг нийслэл, дүүргийн хэмжээнд зохион байгуулахад дараах хяналт шалгалтыг тогтмол хэрэгжүүлж, ажиллахыг нийслэл, дүүргийн Дотоод аудитын албанд үүрэг болгосугай.” заалтууд болон нийслэлийн Засаг даргын 2017 оны 16 дугаар удирдамжийн хүрээнд Шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилтийн үзлэг шалгалтыг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 08 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацааг хамруулан нийслэлийн ТЕЗ-ийн харьяа төсөвт 50, аж ахуйн тооцоот 19 нийт 69 байгууллагад гүйцэтгэсэн.

Аудитын баг Шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилтийн аудитыг гүйцэтгэхдээ <http://shilendans.gov.mn/> цахим хуудсанд харьяа байгууллагуудын байршуулсан мэдээллийг аудитын дуусгавар хугацаа болох 2017 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар баримтжуулсан ба цахим хуудсанд байршуулсан мэдээллийг тухайн байгууллагын санхүүгийн болон бусад холбогдох баримтуудтай харьцуулан тулгаж бүрэн, үнэн зөв эсэхийг магадалсан.

Энэхүү үзлэг шалгалтаар тус хууль болон журмыг хэрэгжүүлээгүй, хангалтгүй хэрэгжүүлж байгаа нийт 4 байгууллагад албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Улаанбаатар хотын Гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих, хөтөлбөр төсөл;
2. “Багахангайн мах боловсруулах үйлдвэр” ОНӨТҮГ;

3. “Нийслэлийн Авто худалдааны цогцолбор” ОНӨААТҮГ;
4. “Улаанбаатар зам засвар арчлалтын газар” ОНӨААТҮГ.

Шалгалтын явцад тайланд тусгагдсан алдаа зөрчлүүдийг дараах байдлаар нөхөн залруулуулсан. Үүнд:

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгааныг тайлбарын хамт 1 байгууллага нөхөн оруулсан, 7 байгууллага төсвийн гүйцэтгэлийн мэдээг зөрүүтэй мэдээлснийг залруулсан.
- Дараа жилийн төсвийн төслийг 12 байгууллага;
- Төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгааныг тайлбарын хамт 3 байгууллага;
- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг 5 байгууллага;
- Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайланг 2 байгууллага;
- Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайланг 7 байгууллага;
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,169,832.2 мянган төгрөг, зарлагын 61,738.5 мянган төгрөгийн гүйлгээг 2 байгууллага;
- Санхүүгийн 2016 оны жилийн эцсийн тайлан, 2017 оны эхний хагас жилийн тайланг 8 байгууллага;
- Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг 1 байгууллага;
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 5 байгууллага;
- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэлийг 5 байгууллага;
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг 3 байгууллага;
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг 2 байгууллага;
- Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн 81 шийдвэрийг 10 байгууллага;
- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг 7 байгууллага;
- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг 2 байгууллага;

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТАЛААР:

Нийслэлийн Дотоод аудитын албаны Эрсдэлийн удирдлагын баг 2017 оны эхний хагас жилд ахлах шинжээч Ц.Болдбаатар, аудитор Б.Уранбилэг, шинжээч Б.Баярмаа нарын бүрэлдэхүүнтэйгээр тайлант хугацаанд ажилласан.

Байгууллагын стратегийг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж болох дотоод, гадаад эрсдэлүүдийг тодорхойлох, үнэлэх, бууруулах үйл явцыг тасралтгүйгээр хэрэгжүүлэх зорилтын хүрээнд албаны алсын хараа, эрхэм зорилгыг хэрэгжүүлэхэд ямар хүчин зүйлүүд тулгарах, тэдгээрт ямар хариу арга хэмжээг авах талаар судлан боловсруулсан. Үүнд:

- Нийслэлийн ТЕЗ-ийн хамрах хүрээний 144 байгууллагын эрсдэлийг үнэлгээ;

- Байгууллагын стратеги төлөвлөгөө;
- Аудитын дунд хугацааны төлөвлөгөө;
- 2017 оны аудитын жилийн төлөвлөгөө;
- Дотоод аудитын шинэчлэгдсэн гарын авлагын дагуу ажлын баримтуудыг шинэчлэх;
- Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн тоон болон бичмэл тайлан.

Дотоод аудитын олон улсын мэргэжлийн практикийн хүрээний хүрээнд дотоод аудит хийх аргачлал загвар, ажлын баримтуудыг шинэчлэн боловсруулах шатанд албаны бүх албан хаагчдад ажлын баримтууд, тэдгээрийн агуулгатай холбоотой сургалт, хэлэлцүүлгийг 3 удаа зохион байгуулсан. Дотоод аудитын шинэчлэгдсэн гарын авлагын дагуу ажлын баримтууд, шинэ аргачлалын дагуу аудитын ажлыг хийж байна.

Гаднаас учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд компьютер, тоног төхөөрөмж, хэрэглээний програмуудын болон дотоод сүлжээний хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна. Үүнд:

- Албан хаагчийн 8 компьютерийн үйлдлийн системийн шинэчлэн суулгаж хэрэглээний програм хангамжийг шинээр суулгаж бэлтгэн өгсөн;
- Өрөөний засвар үйлчилгээний дараах компьютеруудын дотоод сүлжээ болон сүлжээний орчинд ажилладаг тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг ханган ажилласан;
- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад туршилтаар ашиглагдаж буй тоон гарын үсгийн төхөөрөмжийг албаны 3 албан хаагчдад нийслэлийн мэдээллийн технологийн газар болон Үндэсний дата төвтэй гурвалсан гэрээ байгуулж тухайн төхөөрөмжийг хүлээн авч суурилуулсан.

Мөн тус хэлтэс нь 2017 онд нийслэлийн Засаг даргад ирсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэх хяналт шалгалтын багт орж ажилласан. Үүнд:

- Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2017 оны 01 сарын 27 өдрийн А/19 дүгээр тушаалаар баталсан удирдамжийн дагуу Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд хяналт, шалгалт явуулах, үнэлэлт дүгнэлт өгөх ажлын хэсэгт ажиллан тус газрын 2016 оны 10-12 сард хийгдсэн ажлын гүйцэтгэл, хөрөнгийн зарцуулалт, өглөг авлага үүссэн эсэх гэсэн чиглэлээр шалгасан;
- Нийслэлийн Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч нийслэлийн Засаг даргын орлогч Ш.Анхмаагийн 2017 оны 02 дугаар сарын 07-ны өдөр баталсан удирдамжаар нийслэлийн төрийн өмчийн СБД-ийн 1-р дүгээр сургууль, ХУД-ийн 18-р дугаар сургууль, БГД-ийн 13, 93 дугаар сургууль, ЧД-ийн 23 дугаар сургууль, БЗД-ийн Шавь цогцолбор, СХД-ийн 9, 105, 67-р сургууль, БНД-ийн 125-р сургууль, Боловсрол цогцолбор сургууль, Гүн галуутай сургуулиудын үйл ажиллагаатай танилцаж, дүгнэлт гаргаж, зөвлөн туслах, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах чиглэлээр зөвлөмж гаргах ажлын хэсэгт;
- НЗДТГ-ын дарга М.Отгонбаярын 2017 оны 05 сарын 30-нд баталсан удирдамжийн дагуу СБД-ийн 11-р хорооны хэсгийн ахлагчаар ажиллаж байсан иргэн О.Нансалмаагийн нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид хандан гарсан өргөдлийг шалгах ажлын хэсэгт;
- Нийслэлийн Баянгол дүүрэг дэх Цагдаагийн хоёрдугаар хэлтсийн 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 14ж.з/3523 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу “Буман жаалууд” цэцэрлэгийн 2016 оны санхүүгийн баримтуудыг шалгасан;

- Нийслэлийн Засаг даргын 2017 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн А/826 дугаар захирамжийн дагуу ажлын хэсэгт орж ажилласан. Ажлын хэсгээр НЗД-д болон Нийслэлийн Боловсролын газарт ирүүлсэн өргөдлийн дагуу 129 дүгээр цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд.

ХЯНАСАН: НИЙСЛЭЛИЙН ДОТООД
АУДИТЫН АЛБАНЫ ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЖАВЗАН

ТАЙЛАН НЭГТГЭСЭН: ЗАХИРГААНЫ
ХЭЛТСИЙН ДАРГА

Я.САРАНСҮХ

2017 оны 12 дугаар сарын 20